ДОРНОД АЙМАГ
ХАЛХГОЛ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 08 сарын 11 өдөр Дугаар 06/01 Хамардаваа

Санал дэмжих тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ээлжит зургаадугаар хуралдаанаар хэлэлцээд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын Засаг даргын өргөн мэдүүлсэн Монгол улсын Засгийн Засгийн газрын 2016 оны 328 дугаар тогтоолоор батлагдсан хөдөө аж ахуйн "Халхгол" үндэсний бүтээн байгуулалтын бүсийн улсын тусгай хэрэгцээний 500,0 мянган га талбайд нийт 224 нэгж талбарууд давхацсан, байгуулагдсанаас одоог хүртэл үйл ажиллагаа явагдаагүй, хөгжлийн хөтөлбөр, үндсэн чиглэл батлагдаагүй, газрыг үр ашигтай эргэлтэд оруулах ажил хийгдээгүй, давхацсан газартай холбоотой иргэд олон нийтээс өргөдөл, гомдол ирсээр байгаа тул уг тусгай хэрэгцээний 500,0 мянган га газрыг улсын тусгай хэрэгцээнээс цуцлуулах саналыг дэмжсүгэй.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж, холбогдох байгууллагуудад хүргүүлж, үйл ажиллагааны талаар улирал бүр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд танилцуулж байхыг сумын Засаг дарга (Э.Бямбажаргал)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА П.ИТГЭЛТӨГС

2125010217